ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 04 сарын 08 өдөр Дугаар 38 Эрдэнэт

# Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 91 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Эрдэнэт хот байгуулагдсаны 40 жилийн ойн баяр наадмыг Хангайн бүсийн хурдан морины уралдаантай хамтатган 2016 оны 7 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд тэмдэглэхээр тогтоосугай.

1. Монголын тулгар төрийн 2225, Их Монгол улсын 810, Ардын хувьсгалын 95, Эрдэнэт хот байгуулагдсаны түүхт 40 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хороог хавсралтын ёсоор байгуулсугай.

2. Баяр наадмыг зохион байгуулах салбар комиссуудыг томилж, холбогдох зардлын тооцоог гаргаж батлуулах, баяр наадмын арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулахыг Зохион байгуулах хороо /н.Энхбат/-нд тус тус даалгасугай.

ДАРГА Б.МЯГМАРСҮРЭН

C:\Togtool \-A4 doc

001 0483